

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/180/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.02.23	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Ахлах аудитор Утас: 99061829 Ахлах аудитор: Утас: 99061429 Цахим хуудас: www.audit.mn	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn М.Алтантуяа Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Б.Азбаяр Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn
--	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.19 № 2/09
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлд 1,487.6 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж, түүнд ногдох 357.0 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй.

5020074

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,975,768.00</u>	<u>37,697,222.23</u>
33	АВЛАГА	7,142,568.00	3,101,612.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	694,768.12
335	Бусад авлага	7,142,568.00	2,406,843.88
3351	Байгууллагаас авах авлага	7,142,568.00	2,406,843.88
35	БАРАА МАТЕРИАЛ	12,833,200.00	34,595,610.23
354	Хангамжийн материал	12,833,200.00	34,595,610.23
35410	Бичиг хэргийн материал	1,754,110.00	24,506,160.00
35420	Аж ахуйн материал	11,079,090.00	2,115,290.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,336,600.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,051,130.23
35470	Бусад хангамжийн материал	00.00	5,586,430.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>142,998,896.24</u>	<u>349,518,806.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	142,998,896.24	349,518,806.93
392	Биет хөрөнгө	142,998,896.24	348,821,306.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,268,000.00	2,268,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,513,731.99	-1,551,531.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	95,990,000.00	364,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,029,166.90	-78,018,833.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,475,680.00	110,925,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,307,948.12	-61,766,670.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,509,550.00	43,509,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,706,786.75	-31,848,186.79
39217	Ном	313,300.00	313,300.00
393	Биет бус хөрөнгө	00.00	697,500.00
39301	Програм хангамж	450,000.00	1,170,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-472,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>162,974,664.24</u>	<u>387,216,029.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,024,401.39</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,024,401.39	00.00
413	Өглөг	1,024,401.39	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,024,401.39	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>161,950,262.85</u>	<u>387,216,029.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	161,950,262.85	387,216,029.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	206,028,121.00	206,028,121.00
51101	Өмч: - төрийн	206,028,121.00	206,028,121.00
512	Хуримтлагдсан үр дүн	-45,381,524.15	179,884,242.16
51210	Өмнөх үеийн үр дүн	-45,381,524.15	-45,381,524.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	225,265,766.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,303,666.00	1,303,666.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>162,974,664.24</u>	<u>387,216,029.16</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,718,181,500.00	1,768,878,298.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,700,000.00	271,531,798.34
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	271,531,798.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	271,531,798.34
122	Тусламжийн орлого	29,700,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	29,700,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,688,481,500.00	1,497,346,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,434,761,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,434,761,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	228,556,500.00	62,585,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,556,500.00	62,585,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,459,925,000.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,459,925,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,667,396,681.28	1,543,612,532.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,667,396,681.28	1,543,612,532.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,520,889,264.67	1,493,263,648.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	707,195,098.00	594,587,473.76
210101	Үндсэн цалин	707,195,098.00	493,538,377.76
210102	Нэмэгдэл	00.00	65,610,980.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	14,660,000.00
210104	Урамшуулал	00.00	20,778,116.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,935,255.16	77,595,181.14
210201	Тэтгэврийн даатгал	56,182,898.23	60,463,785.69
210202	Тэтгэмжийн даатгал	6,153,104.38	2,780,803.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,922,484.50	8,779,081.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,146,179.12	506,499.19
210205	Эрүүл мэндийн даатгал	13,530,588.93	5,065,011.43
2104	Хангамж, бараа материалын зардал	37,170,999.62	39,060,676.21
210401	Бичиг хэрэг	5,089,700.00	7,087,050.00
210402	Тээвэр, шатахуун	28,781,300.00	29,130,668.11
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,999,999.62	2,842,958.10
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	694,200.00	5,831,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	694,200.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	5,831,800.00
2107	Томилолт, зочны зардал	7,980,000.00	10,469,520.00
210702	Дотоод албан томилолт	3,280,000.00	7,970,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,700,000.00	2,499,520.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	349,336,076.00	342,270,994.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,606,730.00	339,851,803.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	1,940,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	810,000.00	299,680.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	69,346.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,600,000.00	179,511.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	336,577,635.89	423,448,002.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	306,543,400.00	315,187,026.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	35,610,887.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,034,235.89	72,650,089.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,507,416.61	50,348,883.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,150,900.00	49,632,470.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	4,008,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	133,150,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	45,624,470.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,350,316.61	716,413.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,350,316.61	716,413.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,200.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,200.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	50,784,818.72	225,265,766.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	50,784,818.72	225,265,766.31

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,688,481,500.00	1,497,521,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,688,481,500.00	1,497,521,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,434,761,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,434,761,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	228,556,500.00	62,760,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,556,500.00	62,760,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,459,925,000.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,459,925,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,643,091,500.00	1,489,701,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,643,091,500.00	1,489,701,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,496,584,083.39	1,437,512,616.09

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,563,640.50	594,155,180.29
210101	Үндсэн цалин	124,794,300.00	207,976,880.29
210102	Нэмэгдэл	00.00	156,498,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,712,000.00	11,880,000.00
210104	Урамшуулал	577,057,340.50	217,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,270,767.27	74,269,700.00
210201	Тэтгэврийн даатгал	59,527,601.21	50,503,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,132,658.98	5,941,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,362,988.16	4,753,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,565.60	1,188,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,727,953.32	11,883,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,380,399.62	47,992,858.10
210401	Бичиг хэрэг	5,080,800.00	15,007,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,999,600.00	30,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,999,999.62	2,985,658.10
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,694,200.00	6,198,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,694,200.00	1,207,930.00
210604	Урсгал засвар	00.00	4,990,540.00
2107	Томилолт, зочны зардал	7,980,000.00	13,469,520.00
210702	Дотоод албан томилолт	3,280,000.00	7,970,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,700,000.00	5,499,520.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	346,746,076.00	358,610,294.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	326,016,730.00	356,126,103.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	1,940,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	810,000.00	299,680.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	69,346.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,600,000.00	244,511.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,949,000.00	342,816,593.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	306,949,000.00	318,104,106.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	24,712,487.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,507,416.61	52,188,883.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,150,900.00	51,472,470.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	133,150,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	51,472,470.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,350,316.61	716,413.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,350,316.61	716,413.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,200.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,200.00	00.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>45,390,000.00</u>	<u>7,820,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	45,390,000.00	7,820,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,390,000.00	7,820,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,390,000.00	7,820,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,390,000.00	7,820,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-45,390,000.00</u>	<u>-7,820,000.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-176,488,279.74	00.00	31,943,507.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-176,488,279.74	00.00	31,943,507.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,353,397.65	00.00	10,353,397.64
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-45,381,524.15	00.00	161,950,262.85
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-45,381,524.15	00.00	161,950,262.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-45,381,524.15	00.00	161,950,262.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	225,265,766.31	00.00	225,265,766.31
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	179,884,242.16	00.00	387,216,029.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,434,761,500.00	1,434,045,086.09	716,413.9	99.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,434,761,500.00	1,434,045,086.09	716,413.9	99.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,423,261,500.00	1,422,572,616.09	688,883.91	99.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,157,800.00	594,155,180.29	2,619.71	99.99
210101	Үндсэн цалин	207,979,500.00	207,976,880.29	2,619.71	99.99
210102	Нэмэгдэл	156,498,300.00	156,498,300.00	0.00	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,880,000.00	11,880,000.00	0.00	100
210104	Урамшуулал	217,800,000.00	217,800,000.00	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,269,700.00	74,269,700.00	0.00	100
210201	Тэтгэврийн даатгал	50,503,400.00	50,503,400.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	5,941,600.00	5,941,600.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,753,300.00	4,753,300.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,188,200.00	1,188,200.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	11,883,200.00	11,883,200.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	48,084,000.00	47,992,858.10	91,141.90	99.81
210401	Бичиг хэрэг	15,084,000.00	15,007,200.00	76,800.00	99.49
210402	Тээвэр, шатахуун	30,000,000.00	30,000,000.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,985,658.10	14,341.90	99.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,250,000.00	6,198,470.00	51,530.00	99.17
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,250,000.00	1,207,930.00	42,070.00	96.63
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,990,540.00	9,460.00	99.81
2107	Томилолт, зочны зардал	13,500,000.00	13,469,520.00	30,480.00	99.77
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	7,970,000.00	30,000.00	99.63
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,500,000.00	5,499,520.00	480.00	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	353,525,000.00	353,170,294.70	354,705.30	99.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000,000.00	349,966,103.00	33,897.00	99.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00	250,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,940,000.00	1,940,000.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	299,680.50	319.50	99.89
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	00.00	60,000.00	0

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	975,000.00	964,511.20	10,488.80	98.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333475000.00	333316593.00	158,407.00	99.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	308,675,000.00	308,604,106.00	70,894.00	99.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,800,000.00	24,712,487.00	87,513.00	99.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11500000.00	12188883.91	688,883.91	105.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,500,000.00	11,472,470.00	27,530.00	99.76
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,434,761,500.00	1,434,045,086.09	716,413.9	99.95
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,434,761,500.00	1,434,045,086.09	716,413.9	99.95
132001	Орон нутгийн төсвөөс	1,434,761,500.00	1,434,045,086.09	716,413.9	99.95
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00	0.00	100
620001	Удирдах ажилтан	06.00	06.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,760,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,760,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,760,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,560,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,560,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12200000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,760,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн ИТХ нь “Нутгийн өөрийн удирдлагын алсын хараатай бодлого, ил тод хариуцлагатай төрийн үйлчилгээ, иргэдийн бүтээлч санаачилга, өргөн боломжид суурилсан, тогтвортой хөгжлийг бий болгож, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэн аз жаргалтай, амар тайван амгалан, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилго доор үйл ажиллагаа явуулж, байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн ИТХ нь газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 881,886.0 мянган төгрөг буюу 137 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,975.8	37,697.2	17,721.5
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	7,142.6	3,101.6	(4,041.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	12,833.2	34,595.6	21,762.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	142,998.9	349,518.8	206,519.9
Үндсэн хөрөнгө	244,006.5	523,176.5	279,170.0
Хуримтлагдсан элэгдэл	(101,007.6)	(173,657.7)	(72,650.1)
Нийт хөрөнгө	162,974.7	387,216.0	224,241.4
Өр төлбөр	1,024.4	-	(1,024.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	161,950.3	387,216.0	225,265.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	162,974.7	387,216.0	224,241.4

Авлагын дансны үлдэгдэл 3,101.6 мянган болж өмнөх оноос 4,041.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ХХОАТ-ын 4,728.5 мянган төгрөгийн суутган тооцсонтой холбоотой байна. Оны эцэст хувь хүнээс авах авлага 2,025.0 мянга, ЭМНДШ-ийн авлага 687.5 мянга, суутган 7,3 мянга, бусад авлага 381.8 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,495.6 мянган төгрөг болж 21,762.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 122,829.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, шатахууны картын урамшуулал 181.8 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 101,067.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 523,176.5 мянган төгрөг болж 279,170.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 7,820.0 мянга, Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/345 тоот захирамжаар Ланд криузер 200 автомашиныг 219,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 135 дугаар тушаалаар үлдэх өртөг дууссан ланд криузер 200 автомашиныг үнэлж 50,000.0 мянган төгрөгөөр, 26 дугаар тогтоолоор Хьюндэй Соната-7-2023 автомашиныг 15,500.0 мянган төгрөгөөр, тооллогоор 2,350.0 мянган төгрөг, тус тус эзэмшүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын даргын 2023.10.06 ны №84 тоот захирамжаар ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжиж ирсэн 15,500.0 мянган төгрөгийн Хьюндэй Соната-7-2023 автомашиныг Гэгээн сумади цогцолбор сургуульд шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 317,286.0 мянган төгрөг болж 225,265.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 225,265.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 759,171.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 759,171.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 612,296.9 мянган төгрөгөөр нэмж 1,371,468.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 238,975.0, гамшгаас хамгаалах 50,000.0 мянга, зөвлөл хороодын гишүүдийн урамшуулал 31,000.0 мянга, гишүүдийн тойрогт ажиллах зардал 164,000.0 мянган төгрөгийг төсвийн төсөлд тусгаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,434,761.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,434,045.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 716.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,434,045.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 91.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 354.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 158.4 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,128,286.5	1,127,696.6	589.9	99.9
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,000.0	975.2	24.8	97.5
4	80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүд	30,000.0	29,996.7	3.3	100.0
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	11,500.0	11,472.5	27.5	99.8
6	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	213,975.0	213,950.0	25.0	100.0
7	82310 Гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	50,000.0	49,954.1	45.9	99.9
	НИЙТ	1,434.8	1,434.0	716.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас Цагаатгалын мөнгө 40,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 10,200.0 мянга Хамтарсан багийн чадавх бэхжүүлэх төслөөр 12,560.0 мянган төгрөг төвлөрч бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тээвэр, шатахууны зардлын 30,000.0 мянган төгрөгт худалдан авах ажиллагаа зохион байгуулж НИК шатахуун түгээх станц тендерт шалгарч гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 23-нд ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 1,434,761.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,347.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,043.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллагад байр ашиглалтай холбоотой зардал байхгүй бөгөөд гар утасны зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллаа.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээнээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас зөрчилд арга хэмжээ авч ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж аудитаар 1,024.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 43,780.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дүгээр сарын 28-ны өдөр FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,024.4	1	1,024.4	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	43,780.0	3	43,780.0	100%
Нийт дүн	4	44,804.4	4	44,804.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгээгүй

Аудитаар нийт 154,417.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс 357.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 154,060.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 357.0 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,990.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 2. ЭМНДШ-д 1,487.6 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж, түүнд ногдох 357.0 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1-д заасан "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НДШ-д илүү мэдээлсэн 1,487.6 мянган төгрөгт ногдох 357.0 мянган төгрөгийг залруулан суутган тооцож, төсөвт төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.3 Зөвлөмж²

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах зардалд 154,060.0 мянган төгрөг зарцуулснаас 41,000.0 мянган төгрөгийг "Лотус трэвл" ХХК гэх аяллын компани руу шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийн хөрөнгөөр гадаад арга хэмжээ зохион байгуулдаг явдлыг таслан зогсоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд залруулга хийгээгүй	0	0								
Дүн	0	0								

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМНДШ-д 1,487.6 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж, түүнд ногдох 357.0 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн байна.	1	357.0	1	357.0				
Төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах зардалд 154,060.0 мянган төгрөг зарцуулснаас 41,000.0 мянган төгрөгийг "Лотус трэвл" ХХК гэх аяллын компани руу шилжүүлсэн байна.	1	154,060.0					1	154,060.0
Нийт дүн	2	154,417.0	1	357.0			1	154,060.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээнээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас зөрчилд арга хэмжээ авч ажилласан байна.	0	0						
Дүн	0	0						

-----oO-----